



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 250

Улаанбаатар хот

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн  
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон  
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захирал Г.Гансүхтэй байгуулсан контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Гансүхтэй контрактыг “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

300509